

ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД  
ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН  
2018 ОНЫ II УЛИРЛЫН ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА

2018.07.06

Ховд

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай” хуулийн хүрээнд 17 сумын 103 байгууллага, 91 баг, аймгийн төвийн 33 төсөвт байгууллага, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, түүний Тамгын газар, Төрийн албаны зөвлөлийн аймаг дахь салбар зөвлөл, Засгийн газрын 11-11 төв, Угтах үйлчилгээ-Иргэдийн санал хүсэлт хүлээн авах 7043-1111 төвд ирсэн өргөдөл гомдлын мэдээг аймгийн хэмжээнд нэгтгэн гаргалаа. Нийт 9711 өргөдөл, гомдол хүлээн авч, 8934 өргөдөл, гомдлыг шийдвэрлэн хариу өгч, 220 өргөдлийг холбогдох байгууллага албан тушаалтанд уламжилж, 560 өргөдөл шийдвэрлэх хугацаа болоогүй хүлээгдэж, өргөдөл гомдлын шийдвэрлэлт 94.3 хувьтай байна.

Сум байгууллагууд өргөдөл гомдлын мэдээг хугацаандаа ирүүлж хэвшсэн. Мэдээгээ хугацаанд нь ирүүлээгүй болон хугацаа хоцорсон, сум байгууллага байхгүй 100 хувь хамрагдлаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Угтах үйлчилгээ-Иргэдийн санал хүсэлт хүлээн авах 7043-1111 төвд дуудлагаар 62, биечлэн 3 нийт 65 мэдээлэл хүлээн авснаас санал хүсэлт 42, гомдол 23 тус тус бүртгэж холбогдох албан тушаалтанд уламжилж, 65 санал хүсэлтэд хариу өгч, шийдвэрлэлт 100 хувьтай байна.

Засгийн газрын 11-11 төвд нийт 53 санал хүсэлт ирснээс гомдол 24, санал хүсэлт 26, талархал 3, тус тус хүлээн авч, санал хүсэлтийг хуулийн хугацаанд нь уламжлан шийдвэрлүүлэн хаалт хийж, шийдвэрлэлт 100 хувьтай байна.

Үүнд эрүүл мэндийн асуудлаар 11, цахилгааны асуудлаар 2, халамжийн асуудлаар 6, хууль хяналтын асуудлаар 2, байгаль орчны асуудлаар 1, халаалтын асуудлаар 5, бусад асуудлаар 26 иргэн тус тус хандаж,

шийдвэрлэлтийн хугацааг авч үзвэл хурдан 51, удаан 2 байна.

Иргэний танхимд байрлуулсан саналын хайрцгийг журмын дагуу 14 хоног тутамд шалгаж, санал хүсэлт ирээгүй тул Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд албан бичгээр хариу улиралд нэг удаа тайлангийн хамт хүргүүлж байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаарх мэдээг хавсаргав.

**ХОВД АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,  
АЛБАН ТУШААЛТАНД 2018 ОНЫ 2-Р УЛИРАЛД ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН  
ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТИЙН АГУУЛГА /%-аар өссөн дүнгээр\**

2018.07.06

Ховд

1	Ховд	Аймгийн хэмжээнд нийт 9711 өргөдөл ирснээс:	
		-Хүсэлт	9563 / 98.5 %
		-Гомдол	98 / 1.0 %
		-Санал	50 / 0.5%
		1. Бусад	3225 / 33.2 %
		2.Нийгмийн халамжийн асуудлаар	1850 / 19.1 %
		3.Өрхийн мэдээллийн сангийн үйлчилгээтэй холбоотой	1837 / 18.9 %
		4. Газрын асуудлаар	1466 / 15.1 %
		5.Ажил хүссэн	681 / 7.0 %
		6.Иргэний бүртгэл	652 / 6.7 %
<p>-Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 2018 оны 2 дугаар улиралд 0-3 хүртэлх насны хүүхэд асарсаны тэтгэмж 50000 төгрөг олгож эхэлсэн болон өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаа явагдсантай холбогдуулан 1837 иргэн судалгаанд хамрагдах хүсэлт гаргасан байна.</p> <p>-Булган суманд шинэ суурьшлын бүс байгуулагдсантай холбогдуулан 867 иргэн газар эзэмших өргөдөл ирүүлсэн байна.</p>			

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



